



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/398

Номгон

Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны  
менежментийг сайжруулах ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны менежментийг сайжруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга

Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

Салбарын төсвийн төлөвлөлт, санхүүгийн бүртгэл мэдээлэл, тайлангийн нэгтгэл хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч

Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын Ахлах байцаагч

824010973

2.

Эрүүл мэндийн газрын Магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нэгдсэн эмнэлгийн Чанарын албаны дарга

Сувилахуйн албаны дарга

Нэгдсэн эмнэлгийн Санхүүгийн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч

Нэгдсэн эмнэлгийн Үйл ажиллагаа эрхэлсэн орлогч дарга

Нэгдсэн эмнэлгийн Амбулаторын тасгийн эрхлэгч

Нэгдсэн эмнэлгийн Эдийн засагч

Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийн даатгалын эмч


Нэгдсэн эмнэлгийн Халдвар судлаач

Нарийн бичгийн дарга:

Эрүүл мэндийн газрын дарга

2.Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулан, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, менежментийн сайн туршлагыг нэвтрүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, ажлыг чанартай зохион байгуулж, үр дүн, тайланг 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг Ажлын хэсгийн дарга (В.Наранчимэг)-д үүрэг болгосугай.

3.Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН